



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ХОЛБООНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Үндсэн хуулийн эрх зүйн маргаан¹)

ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ НӨӨЦ ХОМС ҮЕД ӨВЧТӨНИЙ ОДОО БОЛОН ОЙРЫН ХУГАЦААНД АМЬД ҮЛДЭХ МАГАДЛАЛД ТУЛГУУРЛАН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ДАРААЛЛЫГ ТОГТООХ НЬ ЭМЧ НАРЫН МЭРГЭЖЛЭЭРЭЭ ЧӨЛӨӨТЭЙ АЖИЛЛАХ ЭРХИЙГ ЗӨРЧСӨН ГЭЖ ҮЗЭВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 1 BvR 2284/23; 1 BvR 2285/23

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 09 сарын 23-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Маргаан бүхий хуулийн 5с дугаар зүйлийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж шийдвэрлэсэн.

МАРГААНЫ ТУХАЙ ТОВЧ

Ковид-19 цар тахлын улмаас 2022 онд Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах тухай хууль (2001)²-д нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Халдварт өвчний улмаас эрчимт эмчилгээний нөөц хомсодсон нөхцөлд авах арга хэмжээ” гэх 5с дугаар зүйлийг шинээр нэмж хуульчилсан байна. Уг зохицуулалтаар халдварт өвчний улмаас эрчимт эмчилгээний ор, тоног төхөөрөмж зэрэг өвчтөний амь насыг аврах нөөц хомсдох үед түүнийг хуваарилах журам, өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх дарааллыг тогтоожээ. Тус дарааллыг тогтоохдоо өвчтөнийг нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл зэрэг аливаа хувийн шинжээр нь ялгаварлахыг эмч нарт хатуу хориглож, харин шийдвэр гаргахдаа баримтлах цорын ганц шалгуурыг “өвчтөний одоо болон ойрын хугацаанд амьд үлдэх магадлал” гэж тодорхойлжээ.

Гомдол гаргагч болох эрчимт эмчилгээний тасгийн эмч нар энэхүү зохицуулалтыг хоёр үндэслэлээр Үндсэн хууль зөрчсөн гэж үзжээ. Нэгдүгээрт, уг асуудлаар хууль тогтоох бүрэн эрх Холбооны хууль тогтоогч байгууллага болох Бундестагт байхгүй тул формаль утгаараа Үндсэн хууль (1949)³-ийг зөрчсөн гэж маргасан байна. Хоёрдугаарт, тус зохицуулалт нь Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт баталгаажсан “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, чөлөөтэй ажиллах” үндсэн эрхэд халдаж, тэдний мэргэжлийн бие даасан шийдвэр гаргах эрхийг хэт хязгаарласан гэж үзжээ. Иймд уг зохицуулалт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулахаар Холбооны Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргасан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

¹Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Entscheidungen/DE/2025/09/rs20250923_1bvr228423.html?nn=68112

² Gesetz zur Verhütung und Bekämpfung von Infektionskrankheiten beim Menschen (IfSG), 2001,
<https://www.gesetze-im-internet.de/ifsg/> (abgerufen am 09.02.2026).

³ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland (GG), 1949, <https://www.gesetze-im-internet.de/gg/BJNR000010949.html> (abgerufen am 09.02.2026).



1. Маргаан бүхий зохицуулалтыг Үндсэн хуульд нийцсэн гэж үзэхийн тулд формаль болон материаллаг шаардлагыг хангах ёстой. Үндсэн хуулийн 74 дүгээр зүйлд Холбооны болон мужийн хууль тогтоох бүрэн эрхэд хамаарах асуудлыг тусгасан бөгөөд тус зүйлийн 1 дэх хэсгийн 19-д заасан “хүн ба малын халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээ” болон 7-д заасан “нийгмийн халамж” хэмээх зохицуулалтад үндэслэн маргаан бүхий зохицуулалтыг хуульчилсан.
2. Үндсэн хуулийн 74 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 19-д Бундестаг нь “хүн ба малын халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээ”-ний талаар хууль тогтоох бүрэн эрхтэй байхаар заасан бөгөөд үүнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварыг хянах, тархалтыг хязгаарлахад чиглэсэн зохицуулалт хамаардаг. Гэвч маргаан бүхий зохицуулалт нь халдварт өвчний цар тахал, дэгдэлттэй холбоотой эрчимт эмчилгээний нөөц хомсодсон үед түүнийг хэрхэн хуваарилахыг тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, халдварт өвчний тархалт, дэгдэлт, түүнтэй тэмцэхтэй холбоотой бус, халдварт өвчний улмаас эмчилгээний нөөцийн хомсдол үүссэний дараах нөхцөлд ямар дарааллаар өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхийг тодорхойлоход чиглэсэн байна. Иймд маргаан бүхий зохицуулалтыг Үндсэн хуулийн 74 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 19-д заасан бүрэн эрхийн хүрээнд хуульчилсан гэж үзэх боломжгүй.
3. Түүнчлэн Үндсэн хуулийн 74 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан “нийгмийн халамж” гэдгийг маргаан бүхий нөхцөлд зөвхөн халдварт өвчин туссан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх зэрэг хязгаарлагдмал халамжийн үйлчилгээний хүрээнд ойлгоно. Маргаан бүхий зохицуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас хамгаалах зэрэг халамжийн шинжтэй элемент агуулж байгаа боловч агуулгын хувьд нийгмийн халамжийн үйлчилгээг зохицуулахад бус, харин эмчилгээний нөөцийн хомсдолын үед эмч нарын мэргэжлийн шийдвэр гаргалт, эмнэлгийн дотоод журамд баримтлах шалгуур тогтоох асуудалд чиглэж байна. Иймд маргаан бүхий зохицуулалт нь Үндсэн хуулийн 74 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан бүрэн эрхийн хүрээнд хамаарахгүй. Ийнхүү дээрх хоёр үндэслэлээр маргаан бүхий зохицуулалт формаль шаардлагыг хангахгүй.
4. Материаллаг шаардлагын хүрээнд маргаан бүхий зохицуулалтын агуулга нь Үндсэн хуульд нийцсэн байх ёстой. Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “иргэн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, чөлөөтэй ажиллах эрхтэй” гэж заасны дагуу эмчийн мэргэжлээрээ чөлөөтэй ажиллах эрх мөн адил хамаарна. Эмчийн мэргэжлээр чөлөөтэй ажиллах гэдэг нь өвчтөнийг анагаах ухаанд тогтсон стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу эмчлэх, түүнчлэн зохистой эмчилгээний аргыг бие даан сонгох боломжийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, эмч нь мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээний хүрээнд тухайн өвчтөнийг эмчлэх эсэх, хэрхэн эмчлэх талаарх шийдвэрийг гаднын нөлөөлөл, зааварчилгаанаас ангид байдлаар гаргах эрхтэй. Тэрээр өөрийн мэдлэг, туршлага, мэргэжлийн дүгнэлтэд тулгуурлан тухайн тохиолдол бүрд өвчтөний онцлогт тохирсон, хамгийн оновчтой эмчилгээний аргыг сонгох боломжтой байх ёстой. Гэтэл маргаан бүхий зохицуулалтаар “өвчтөний одоо болон ойрын хугацаанд амьд үлдэх магадлал”-д тулгуурлан эрчимт эмчилгээ хийх дарааллыг урьдчилан тогтоосон нь эмчийн эмчилгээ хийх эсэх болон



ямар эмчилгээний аргыг хэрэглэх талаарх мэргэжлийн бие даасан шийдвэр гаргах эрх чөлөөг нь хязгаарлаж байна. Иймд тус зохицуулалт нь эмчийн мэргэжлээр чөлөөтэй ажиллах үндсэн эрхэд халдаж байна гэж үзэх үндэслэлтэй бөгөөд энэ утгаараа **материаллаг шаардлагыг мөн хангаагүй** гэж дүгнэхээр байна.

5. Дээрх үндэслэлээр Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах тухай хуулийн 5с дугаар зүйлийг Үндсэн хуульд нийцээгүй, хүчин төгөлдөр бус гэж шийдвэрлэжээ.

---o0o---